

БАТЛАВ.МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД



### 1. Аудитын нэр

Концессын тухай хуулийн хэрэгжилт

### 2. Аудитын код: УАГ- НАГ/2014/04-НА

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны даргын 2014 оны 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитораас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### 4. Аудитын зорилт

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хуулийн хэрэгжилт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

- I. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн болон концессыг хэрэгжүүлэх орчин бүрэлдсэн эсэх;
- II. Төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;
- III. Концессын гэрээгээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

### 5. Аудитын хамрах хүрээ

Концесс хэрэгжүүлэгч Төрийн захиргааны төв байгууллагууд болон орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж, иргэд хамрагдана.

### 6. Үндсэн мэдээлэл

“Концесс” гэж гэж төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрхийг хэлнэ.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхүүлэн дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болох зорилгоор УИХ-аас 2009 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, 2010 онд Концессын тухай хуулийг тус тус баталсан байна.

Түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилт нь дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, нэгдсэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийг Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Концессын хэлтэс хэрэгжүүлж байна.

Концессын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын Засгийн газраас 122 концессийн зүйлийн жагсаалт баталж, 2013 оны 317 дугаар тогтоолоор тус жагсаалтыг хүчингүй болгож, 133 концессын жагсаалтыг шинээр баталсан байна.

## 7. Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

## 8. Аудитын арга зүй

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, аудитын арга зүйг ашиглана.

Төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ байгуулах, концессын хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Эдийн засгийн хөгжлийн яам болон бусад салбарын яамд, орон нутгийн засаг захиргааны нэгжийн холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, судалгаа авах, Засгийн газраас баталсан концессийн зүйлийн жагсаалтын дагуу байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

## 9. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Үндсэн хууль
- Иргэний хууль
- Концессын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
  - УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам
  - Холбогдох бусад хууль тогтоомж

## **10. Аудит хийх бүрэлдэхүүн**

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа хяналт тавьж, ахлах аудитор Л.Хонгорзул, ахлах шинжээч Я.Наранцэцэг, аудитор Д.Дорждулам, шинжээч Л.Нямтэмэр, Б.Билэгт, Ш.Наранбаатар аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид гүйцэтгэнэ.

## **11. Аудит хийх хугацаа**

Аудитыг 2014 оны 8 дугаар сарын 15-нд эхэлж, 2014 оны 12 дугаар сарын 5-нд дуусгаж, 12 дугаар сарын 20-ны дотор УИХ-д танилцуулна.

Аймаг, нийслэлийн аудитын газрууд аудитын тайланг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны дотор ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт ирүүлнэ.

## **12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам**

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг Монгол Улсын Ерөнхий аудитор болон УИХ-д танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

## **13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц**

- а. Боловсон хүчин: ҮАГ- 72 өдөр \*8хүн- 576 хүн/өдөр
- б. Орон нутгаас: 63 өдөр\*48 хүн- 3024 хүн/өдөр
- в. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал: 141,120.0 мянган төгрөг
- г. Үйл ажиллагааны зардал: 338,688.0 мянган төгрөг
- д. Аудитын нийт зардал: 479,808.0 мянган төгрөг
- е. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, скайнер, дектафон, болон бусад техник хэрэгсэл

## **Аудитын төлөвлөгөөг**

Хянаж зөвшөөрсөн:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН

ДЭД ДАРГА

Б.БАТТУЯА

Боловсруулсан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА



АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АЛТАНЗУЛ

АХЛАХ АУДИТОР

З.АРИУНЗАЯА

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Л.ХОНГОРЗУЛ

Я.НАРАНЦЭЦЭГ